



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 03 сарын 19 өдөр

Дугаар 39

Номгон

“Даншиг наадам-2019” сугалаа
гаргахыг зөвшөөрөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.10, 20.1.14 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Монголын шашин төрийн нэрт зүтгэлтэн, Их соён гэгээрүүлэгч, Монголын маарамбын оройн чимэг, Хамба номун хан, ханчин чойжил Эрдэнэбандинд хутагт, ууган зурхайч, Монголын бурхны шашны 3 зулын нэг Ламын гэгээн Лувсанданзанжанцаны түмэн өлзий гийсний түүхт 380 жилийн ой, түүний наймдугаар дүр Данзанжамбалчойжишэнин гэгээнтэнд бат оршил өргөх хүндэтгэл, даншиг наадам, Монголын Тулгар төрийн 2228 жил, Их Монгол Улсын 813 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтолоо сэргээн мандуулсны 108 жил, Ардын хувьсгалын 98 жил, аймаг байгуулагдсаны 78 жилийн ойн баярууд давхацсан түүхэн их ой зохион байгуулах санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтыг нэмэгдүүлж, иргэдийн амьжиргааг дэмжих зорилгоор аймгийн хэмжээнд “Даншиг наадам-2019” сугалаа гаргах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д зөвшөөрсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд 2019 оны 3 дугаар улиралд багтаан тайлагнахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/, хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/ нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА Ц.ОТГОНБАЯР

D:/2018/Alban bichig/th togtoo/2019
111001